



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ДЭРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А/01

Цант

“Хувь хүний хөгжлийг дэмжих жил”
болгон зарлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2., 59.1.3., 66 дугаар зүйлийн 66.1., Сумын “Засаг даргын 2020 оноос 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4 дэх хүрээний зорилго, зорилт 4.2.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэд, гэр бүл, хүүхэд, залуучуудыг хөгжүүлэх, тэдгээрийн идэвх санаачлагыг дэмжих, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, сурч боловсрох, эрхэлсэн ажилдаа дадлагажих, хөгжин дэвших боломж нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 2022 оныг “ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЖИЛ” болгон зарласугай.

2.2022 онд “Хувь хүний хөгжлийг дэмжих жил”-ийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3.“Хувь хүний хөгжлийг дэмжих жил” болгосонтой холбогдуулан сумын иргэд, албан байгууллага, аж ахуй нэгжүүдэд идэвх санаачлага гарган үр бүтээлтэй хамтран ажиллахыг уриалсугай.

4.“Хувь хүний хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж удирдлага зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилт үр дүнг тооцож ажиллахыг сумын ажлын хэсгийн ахлагч Засаг даргын Тамгын газрын дарга (Г. Зулбаатар), 2022 оны төлөвлөгөөний зорилт арга хэмжээнд шаардагдах зардлын эх үүсвэрийг шийдвэрлэж ажиллахыг төрийн байгууллагын дарга, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Л. АМАРТҮВШИН

48122015